

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 20.9-д заасан ажлын хэсэг Нийт шүүгчийн чуулганыг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулж, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнийг сонгоно. Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл хамтран хариуцна.

/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

2 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүн томилогдох, эсхүл сонгогдох хүртэлх хугацаанд 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдөр баталсан Шүүхийн захиргааны тухай хуулийн дагуу томилогдсон Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн ёс зүйн хороо, Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17.1.2-т заасан үндэслэлээр шүүгчийн бүрэн эрх нь түдгэлзсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний шүүгчийн бүрэн эрх Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн дараагийн гишүүн сонгогдсоноор сэргээсэнд тооцно.

3 дугаар зүйл.2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17.1.5, 17.1.8-д заасан үндэслэлээр шүүгчийн бүрэн эрх нь түдгэлзсэн шүүгчийн бүрэн эрхийг сэргээх эсэх асуудлыг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу Шүүхийн сахилгын хороо шийдвэрлэнэ.

4 дүгээр зүйл.2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсан Шүүхийн захиргааны тухай хуулийн 23.6.1-д заасны дагуу Шүүхийн мэргэшлийн хорооны гаргасан үнэлгээгээр шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчийн үнэлгээ мөн хуулийн 23.7-д заасан хоёр жилийн үлдсэн хугацаанд хүчинтэй байна.

5 дугаар зүйл.Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтцэд байгаа Шүүхийн ёс зүйн хорооны ажлын албаны ажилтан, эд хөрөнгийг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дагуу байгуулагдах Шүүхийн сахилгын хороонд шилжүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл зохион байгуулна.

6 дугаар зүйл.Шүүхийн сахилгын хороо байгуулагдах хүртэлх хугацаанд шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаар гарсан гомдол, маргааныг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө уг харилцааг зохицуулж байсан хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Шүүхийн сахилгын хороо байгуулагдсан бол Шүүхийн ёс зүйн хороо, Захиргааны хэргийн давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааныг Сахилгын хороонд шилжүүлнэ.

7 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдсон шүүгчийн бүрэн эрхийг энэ хууль хөндөхгүй бөгөөд Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн танхимын тэргүүний бүрэн эрх нь Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 36.8, 36.9-д заасны дагуу тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс Ерөнхий шүүгч сонгогдсон, 36.10-т заасны дагуу танхимын тэргүүн сонгогдсоноор дуусгавар болох бөгөөд энэ нь шүүгчийн бүрэн эрхийг хөндөх үндэслэл болохгүй.

8 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор сонгон шалгаруулж, томилно.

/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

9 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохоос өмнө шүүхэд ажиллаж байгаа хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй шүүгчийн туслах Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 89.1-д заасан шаардлагыг уг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд хангана.

10 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг батлахаас өмнө Улсын Их Хуралд танилцуулахаар ирүүлсэн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчид Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 36.2, 36.3 дахь хэсгийн зохицуулалт хамаарахгүй.

11 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 46.2-т заасан нэмэгдлийг 2022 оны 01 дүгээр